

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

“А” Нийтлэг үндэслэл

Байгууллагын нэр		Нэгжийн нэр	
УХТЭ		Мэс заслын тасаг	
Ажлын байрны нэр		Ангилал	Зэрэглэл
Аж ахуйн нярав		ТҮ	2
Шууд харъяалагдах ажлын байр (албан тушаал)		Шууд харъяалах ажлын байр (албан тушаал)	
Тасгийн эрхлэгч, арга зүйч, сувилагч, нярав сувилагч			
Ажлын байрны зорилго		Хагалгааны ба тасгийн ариутгал цэвэрлэгээг хийх , хүнд хэвтрийн эмчлүүлэгчдэд туслах	
Ажлын байрны үндсэн үүрэг		- Хагалгааны ба тасгийн цэвэрлэгээг цаг тухайд нь чанартай хийх - Тусламж үйлчилгээг чанартай үзүүлэх -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, халдвар эсэргүүцэх дэглэмийг мөрдөн ажиллах - Хууль дүрмийн дагуу ажиллах	

Б. Ажлын байрны чиг үүрэг

Ажлын байрны гол үйл ажиллагаа	Хугацаа хуваарь
<u>Ажлын байрны I үндсэн зорилтын хүрээнд:</u> - Ажлын байранд ажлын цаг эхлэхээс 10 минутын өмнө ирж хариуцсан талбай тус бүрээр явж цэвэрлэгээг шөнийн ээлжнээс хүлээж авна - Их цэвэрлэгээ болон урсгал цэвэрлэгээг стандартын дагуу хийж гүйцэтгэнэ. - Цэвэрлэгээнд ариутгалын бодисыг тогтмол хэрэглэнэ - Бохир болон цэвэр хэрэглэлийг няравын хамтаар угаалгын тасагт хуваарьт өдөр хүргэж өгч авна - Цэвэрлэгээний материалыг төрөлжүүлэн нэр хаяг хийж эмх цэгцтэй хадгалж, зөв хэрэглэнэ. - Бие засах газрын ариун цэврийг тогтмол шалгаж цэвэр байлгах - Хог хаягдлыг цаг тухайд нь зориулалтын хогийн цэгт устгах - Хагалгаа хоорондын цэвэрлэгээ, ариутгалыг тогтмол хийх - Бохир болон цэвэр хэрэглэлийг угаалгын тасагт хуваарьт өдөр хүргэж өгч авна - Ажлын дүрэмт хувцасыг бүрэн өмсөх - Халдвар хамгааллын дэглэмийг чанд сахих - Эмнэлгийн ажилтны ёс зүйн хэв хэмжээг баримлан ажиллах	- Тогтмол
<u>Ажлын байрны II үндсэн зорилтын хүрээнд:</u> - Үйлчлүүлэгч төвтэй – Үйлчлүүлэгчийн сонголт , хэрэгцээ болон чанарыг хүндэтгэн, өвчтөн хувь хүний асуудлыг шийдэж байх - Цаг хугацаанд нь үйлчилгээг хүргэх – Үйлчилгээ авч буй болон үзүүлж байгаа хүмүүсийн хүлээгдэл чирэгдлийг багасгах - Бүтээмжтэй – Тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, хүч хөдөлмөр, бодол санаа зэргээ дэмий үр ашиггүй зарцуулалтаас зайлсхийх - Тэгш шударга – Хувь хүний шинж байдлаас үл шалтгаалан (хүйс, яс	- Тогтмол

үндэс, газар зүйн байрлал, нийгэм эдийн засгийн байдал) тусламж үйлчилгээг хүргэх	
<u>Ажлын байрны III үндсэн зорилтын хүрээнд:</u> - Эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэх, холбогдох дүрэм, журам, тушаал зааврыг мөрдөж ажиллах - Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан ажиллах - Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааврын дагуу ажиллуулж, зориулалтын дагуу ашиглах, хамгаалах - Өөрийн тасаг, нэгжид ашиглагдаж байгаа бүх тоног төхөөрөмжийг ашиглах чадвартай байх	Тогтмол
<u>Ажлын байрны IV үндсэн зорилтын хүрээнд:</u> Байгууллагын үйл ажиллагаагаанд мөрдөж буй Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээ болон бусад хууль дүрэм, журам, стандарт болон холбогдох зааврыг мөрдөж ажиллах - Байгууллагаас зохиож буй соёл, урлаг, биеийн тамир болон бусад олон нийтийн ажилд тасаг, хамт олноо төлөөлөн оролцох - Байгууллагаас зохион байгуулж буй сургалтанд оролцох	-Тогтмол

В.Тавигдах шаардлага



1 Ажлын байранд тавигдах шаардлага	1.1 Ерөнхий шаардлагууд	Үзүүлэлт	Зайлшгүй шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Бүрэн бус дунд	Боловсролын үнэмлэх
		Мэргэжил		
		Мэргэшил		
		Туршлага	Эмнэлэгт ажиллаж байсан тодорхой ажлын туршлагатай	
		Нэмэлт ур чадвар	- Ажлын дадлага туршлагатай байх - Багаар ажиллах чадвартай	
	1.2 Тусгай шаардлага	Ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллах - Үйл ажиллагаагаа “Авилгын эсрэг хууль”-ийн хүрээнд явуулж, авилгаас ангид байх Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001 стандартын зохих мэдлэгтэй байна		

Г. Хүчин зүйлс

1. Ажлын байрны харилцах субъект		
1.3 <u>Байгууллагын дотор талд байгаа:</u> Байгууллагын дарга, тасгийн эрхлэгч эмч, тасгийн эмч, сувилагч, эмнэлгийн бусад ажилчид	1.4 <u>Байгууллагын гадна талд байгаа:</u> -Үйлчлүүлэгчийн ар гэртэй, үйлчлүүлэгчийн асуудлаар	
2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага	Ажлын байрны үндсэн чиг үүрэгт заасан үйл ажиллагаатай холбоотой асуудлыг эмнэлгийн дарга/тасгийн эрхлэгчийн өмнө хариуцна.	
3. Ажлын байрны нөөц хэрэгсэл	3.1 Санхүүгийн: - Цалин (ТҮ-2)	Нэмэгдэл хөлс: -Хууль тогтоомжоор олгогдох бусад нэмэгдэл ба нэмэгдэл хөлс

	3.2 Материалын:	- Ажлын хувцас 2 удаагийн - Халдвар хамгааллаас хамгаалах хэрэгсэл -Цэвэрлэгээний хэрэгсэл
	3.3 Хүний:	
	3.4 Бусад	Жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдах
4.Ажлын байрны нөхцөл	Хэвийн	
5.Орлон ба хавсарч ажиллах ажлын байрны нэр	Үйлчлэгч	

Д. Баталгаажуулалт

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан	Ажлын байрны тодорхойлолтыг баталсан	Ажлын байрны тодорхойлолттой танилцаж зөвшөөрсөн
Эмнэлгийн захирал  2010 оны сарын өдөр	Тасгийн эрхлэгч  2010 оны сарын өдөр	Тасгийн үйлчлэгч /М. Жавзандулам /  2010 оны сарын өдөр